

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2026 оны 04 дүгээр сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Аж ахуйн нэгж
11. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



ЭДИЙН ЗАСАГ 2025 ОНД

ДНБ-ий өсөлт

(2025 он)

6.8 хувь

Гадаад валютын нөөц

(2025 он)

7,005 сая \$

Инфляц

(2025 оны 12 дугаар сар)

7.5 хувь

Төсвийн тэнц.

тэнцэл

(2025 оны 12 дугаар сар)

-1,232 тэрбум ₮

Экспорт

(2025 он)

15.7 тэрбум \$

Импорт

(2025 он)

11.3 тэрбум \$

ГШХО

(2025 он)

3.8 тэрбум \$

Зээлийн хүү

(2025 оны 12 дугаар сар)

17.2 хувь

Ажиллагчдын тоо

(2025 оны 4 дүгээр улирал)

1.38 сая

*IV улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 62.3 хувь байна.

Бодит цалин

(2024 оны 4 дүгээр улирал)

2.4 сая

*ХҮИ 2023=100

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2025 оны 4 дүгээр улирал)

116.8 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2025 оны 4 дүгээр улирал)

5.0 хувь

ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД – 2026.04

ДНБ-ий өсөлт

(2026 оны 1 дүгээр улирал)

7.9 хувь

Гадаад валютын нөөц

(2026 оны 4 дүгээр сар)

7,327 сая \$

Инфляц

(2026 оны 4 дүгээр сар)

10.1 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2026 оны 4 дүгээр сар)

-1,425 тэрбум ₮

Экспорт

(2026 оны 4 дүгээр сар)

6.8 тэрбум \$

Импорт

(2026 оны 4 дүгээр сар)

3.7 тэрбум \$

ГШХО

(2025 он)

3.8 тэрбум \$

Зээлийн хүү

(2026 оны 4 дүгээр сар)

17.5 хувь

Ажиллагчдын тоо

(2026 оны 1 дүгээр улирал)

1.34 сая

*1 улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 60.4 хувь байна.

Бодит цалин

(2026 оны 3 сар)

2.3 сая

*ХҮИ 2023=100

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2026 оны 1 дүгээр улирал)

117.3 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт


(2025 оны 4 дүгээр улирал)

5.0 хувь



Эдийн засгийн өсөлт 2026 оны 1 дүгээр улиралд 7.9 хувьд хүрлээ. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл эрчимжсэнээр нийт өсөлтийг дэмжив. Хөдөө аж ахуй, барилга, эрчим хүчний салбар өсөлтийг дэмжсэн бол боловсруулах, худалдааны салбар агшиж өсөлтийг сааруулсан хэвээр байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ
(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ
(салбараар)

ДНБ	2025.I	2026.I
Хөдөө аж ахуй	35.6	11.4
Уул уурхай	0.7	33.6
Боловсруулах	5.3	-6.6
Цахилгаан, ус	5.5	8.0
Барилга	-0.8	9.5
Худалдаа	-5.5	-0.8
Тээвэр	-11.4	23.8
Мэдээлэл, холбоо	17.5	6.6
Үйлчилгээний бусад	6.1	2.7
Цэвэр татвар	-3.1	1.1


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УУЛ УУРХАЙ
(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨДӨӨ АЖ АХУЙ
(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бодит ДНБ 2026 оны эхний улиралд **7.9 хувиар өслөө.**
- Анхдагч салбар: Хөдөө аж ахуй 11.4 хувиар тэлж, өсөлтийн 0.4 нэгж хувийг, уул уурхай 33.6 хувиар тэлж, өсөлтийн 5 нэгж хувийг бүрдүүлэв.
- Хоёрдогч салбар /барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 8.7 хувиар өсөж өсөлтийн 0.5 нэгж хувийг бүрдүүлсэн бол боловсруулах салбар 6.6 хувиар буурч, өсөлтийг 0.4 хувиар хязгаарлав.
- Үйлчилгээний салбар /худалдаанаас бусад үйлчилгээний салбарууд өссөн/ 4.1 хувиар өсөж, өсөлтийн 2.2 хувийг бүрдүүллээ.
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 1.1 хувиар өсөж, өсөлтийг 0.2 нэгж хувиар дэмжив.




- Эдийн засгийн өсөлтийг уул уурхай, тээвэр, хөдөө аж ахуйн салбарын өсөлт голлон дэмжсэн бол боловсруулах, худалдааны салбар агшиж өсөлтийг саарууллаа.
- Барилга, цахилгаан, усан хангамж, мэдээлэл холбооны салбарын үйлдвэрлэл нэмэгдэж өсөлтөд эергээр нөлөөллөө.
- Хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа буурсны голлох нөлөөгөөр худалдааны салбар агшилттай байна.

- Уул уурхайн салбар 2026 оны эхний улиралд 33.6 хувиар өслөө.
- Үүнд нүүрс олборлолт 38.3 сая тоннд хүрч, өмнөх оноос 4 хувиар, зэсийн баяжмал үйлдвэрлэл 0.8 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30 хувиар өссөн нь голлон нөлөөллөө.

- Хөдөө аж ахуйн салбар 2026 1 дүгээр улиралд 11.4 хувиар өслөө.
- Өвөлжилт харьцангуй хэвийн байсан ч хаврын саруудад зарим нутгаар цас, шороон шуургатай хүйтэн байж, бойжсон төлийн тоо толгой 4.2 саяд хүрч (төл бойжилт 98.8 хувь) өмнөх оны мөн үеэс 426 мянган толгой малаар буурч, том малын зүй бус хорогдол 178 мянган толгод хүрч өмнөх оны мөн үеэс 94 мянган толгой малаар өссөнөөр хөдөө аж ахуйн салбарын өсөлтийн эрчим саарах хандлага ажиглагдав.



Өсөлтийг эрэлт талаас цэвэр экспорт, өрхийн хэрэглээ голлон дэмжлээ.



- Эдийн засгийн өсөлтийг гадаад эрэлт голлон дэмжив. Нийт өсөлтийн 16.6 нэгж хувийг цэвэр экспорт, 6.4 нэгж хувийг өрхийн хэрэглээ бүрдүүлсэн байна.
- Харин нийт хөрөнгийн хуримтлалын бууралт өсөлтийг 15.0 нэгж хувиар бууруулсан байна.

- Төрийн хэрэглээ бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 9.7 хувиар, өрхийн хэрэглээ 4.9 хувиар тус тус өслөө.

- Үндсэн хөрөнгийн хуримтлал 16.6 хувиар буурахад машин тоног төхөөрөмжийн хуримтлал өмнөх оноос 34.8 хувиар буурсан нь голлон нөлөөллөө.

- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 44.8 хувиар, импорт үргэлжлэн саарч 9.3 хувиар агшсанаар цэвэр экспортод эерэг нөлөө үзүүлж байна.




Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 4 дүгээр сард 54.1 хувиар өсөв. Уул уурхайн салбарт нүүрс, зэс болон төмрийн хүдрийн олборлолтын биет хэмжээ өссөн нь голлон нөлөөллөө.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ (тэрбум төгрөг)



- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2026 оны 4 дүгээр сард 21.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 54.1 хувиар өслөө.
- Газрын тос болон цайрын баяжмал үйлдвэрлэл буурсан ч нүүрс, металлын хүдэр олборлолт өссөнөөр салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 67.5 хувиар өслөө.
- Ундаа болон хүнсний бүтээгдэхүүн, химийн бодис болон химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нөлөөгөөр боловсруулах салбар (нэрлэсэн дүнгээр) 2026 оны 4 дүгээр сард 8.4 хувь өслөө.

НҮҮРС ОЛБОРЛОЛТ (сая тонн)



- Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 80 орчим хувийг* уул уурхайн салбар, түүний дотор 40 орчим хувийг нүүрсний олборлолт эзэлдэг.
- Нүүрсний олборлолт 2026 оны 4 дүгээр сард 38.3 сая тонн болж, өмнөх оноос 42.4 хувиар өслөө.


УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ (голлох бүтээгдэхүүнээр)

Төрөл	Хэмжээ	Өмнөх оноос өөрчлөлт:
Зэсийн баяжмал	798 мян.тонн	29.5%
Газрын тос	1,183 мян. баррель	-7.2%
Алт	2.7 тонн	7.8%
Төмрийн хүдэр	2.3 сая.тонн	44.4%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- 2026 оны 4 дүгээр сард зэсийн баяжмалын үйлдвэрлэл 29.5 хувиар өсөж 798 мянган тоннд хүрэв.
- Төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэл 2.3 сая тоннд хүрч, 44.4 хувиар өссөн байна.
- Алт олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс 7.8 хувиар өсөж 2.7 тоннд хүрэв.
- Харин, газрын тос олборлолт 7.2 хувиар буурлаа.

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2024=100)



- Үйлдвэрлэгчийн үнийн индекс 2026 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 22.8 хувиар өссөн байна.

- Үнэ өссөн:
- Газрын тос, байгалийн хий олборлолт 80.2 хувиар;
 - Металлын хүдэр олборлолт 56.9 хувиар;
 - Цаас болон цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 49.6 хувиар;
 - Хими, химийн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 56.5 хувиар;

- Үнэ буурсан:
- Нүүрс олборлолт 1.3 хувиар


*2025 оны байдлаар



Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны дөрөв дүгээр сард бодит дүнгээр 4.6 хувиар буурав. Үүнд мах боловсруулах үйлдвэрлэл, ундааны үйлдвэрлэл болон металл боловсруулах үйлдвэрлэл буурсан нь голлон нөлөөлсөн байна.

МАХ


(МЯН. ТОНН)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГУРИЛ


(МЯН. ТОНН)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УНДАА


(МЯН. ТОНН)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

САМНАСАН НООЛУУР

(ТОНН)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Боловсруулсан малын мах 2026 оны 4 дүгээр сард 4.8 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 53 хувиар буурлаа.
- Боловсруулсан махны биет хэмжээ буурснаар боловсруулах салбарын 8-10 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах, консервлох үйл ажиллагааны бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оноос 21.4 хувиар буурлаа.

- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 4 дүгээр сард 52.8 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар өссөн байна.
- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ өсөж боловсруулах салбарын 5-7 орчим хувийг бүрдүүлдэг гурил болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний үйлдвэрлэл бодит дүнгээр (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оны орчимд байна.


- Согтууруулах болон согтууруулах бус ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 4 дүгээр сард 159 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 13 хувиар буурлаа.
- Үйлдвэрлэлийн биет хэмжээ буурч боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг ундааны бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар буурсан байна.

- Самнасан ноолуурын үйлдвэрлэл 2026 оны 4 дүгээр сард 187 тонн болж, өмнөх оны мөн үеэс 41 хувиар өслөө.
- Ноолуурын үйлдвэрлэлийн биет хэмжээ өссөн ч боловсруулах салбарын 3-5 орчим хувийг бүрдүүлдэг ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оноос 6.6 хувиар бага байна.



Барилгын салбарын үйлдвэрлэлийн голлох орц болох цемент, вакум цонх болон хаалга, металл бэлдэц болон цувимлын үйлдвэрлэл нэмэгдсэн бол катодын зэсийн үйлдвэрлэл буурсан байна.


ЦЕМЕНТ
(мян. тонн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

▪ Цемент үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 4 дүгээр сард 401 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 44 хувиар өсөөд байна.


КАТОДЫН ЗЭС
(тонн)



Эх сурвалж: ЭЭХЯ-ны тооцоолол, ҮСХ

▪ Катодын зэс үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 4 дүгээр сард 2,183 тонн болж, өмнөх оны мөн үеэс 16.4 хувиар буураад байна.


МЕТАЛЛ БЭЛДЭЦ, ЦУВИМАЛ
(мян. тонн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

▪ Металл бэлдэц болон цувимал бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 4 дүгээр сард 25.5 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар өсөөд байна.

ВАКУМ ЦОНХ, ХААЛГА
(мян. м.кв)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

▪ Вакум цонх, хаалганы үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 4 дүгээр сард 11.9 мянган м.кв болж, өмнөх оны мөн үеэс 42 хувиар өслөө.



Нүүрс тээвэр нэмэгдсэнээр тээврийн салбарын ачаа тээвэр нэмэгдлээ. Инфляцаар засварласан дүнгээр худалдаа, зочид буудлын салбарын бодит орлого буурсан бол нийтийн хоолны салбарын бодит орлого өссөн байна.



- Үйлчилгээний салбарын дийлэнхийг бөөний болон жижиглэн худалдааны салбар бүрдүүлдэг.
- Тус салбарын борлуулалтын орлого 2026 оны 3 дугаар сард нэрлэсэн дүнгээр 15 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 663 хувиар өссөн бол үнийн нөлөөг засварласан бодит дүнгээр 0.7 хувиар буурсан байна.



- 2026 оны 3 дугаар сард нэрлэсэн дүнгээр зочид буудлын салбарын борлуулалтын орлого 6.4 хувиар өссөн бол нийтийн хоолны салбарын борлуулалтын орлого 8.4 хувиар өссөн байна.
- Үнийн нөлөөг засварласан зочид буудлын салбарын бодит орлого 1 хувиар буурсан бол нийтийн хоолны салбарын бодит орлогын дүн 0.8 хувиар өссөн байна.


ТЭЭВЭР

(тээсэн ачаа, сая тонн)

	2025.04	2026.04	ӨМНӨХ ОНООС:
Төмөр зам	13.6	20.1	48.1%
Уул уурхайн бүт.	9.8	15.4	56.7%
Агаар*	2.93	2.89	-1.3%
	2025.1	2026.1	
Авто зам	18.4	28.6	55.1%
Уул уурхайн бүт.	12.2	18.7	52.5%

*мянган тонн
Тэмдэглэл: Авто замын тээврийн статистик улирлаар зарлагддаг.
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Төмөр замаар 2026 оны 4 дүгээр сарын байдлаар 20.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48.1 хувийн өсөлттэй байна.
- Агаараар тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үеэс 1.3 хувийн бууралттай байна.
- Авто замаар 2026 оны 1 дүгээр улиралд 28.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 55.1 хувийн өсөлттэй байна.




- 2026 оны эхний дөрвөн сарын байдлаар Монгол Улсын хилээр орсон жуулчдын тоо 208 мянга болж, өмнөх оны мөн үеэс 35.3 хувиар өссөн байна.



2026 оны 4 дүгээр сарын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 10.5 тэрбум ам.долларт хүрсэн бол худалдааны тэнцэл 3.1 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.


ЭКСПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Экспорт 4 дүгээр сард 6,813 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 61 хувиар өслөө.
- Нийт экспортын 95 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүлээ.


ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспортын орлого 2,567 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 40 хувиар өслөө.
- Зэсийн баямжалын экспортын орлого 3,080 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 124 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 383 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 36 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 187 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6 хувиар өслөө.


ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- 2026 оны 4 дүгээр сард импорт 3,669 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3 хувиар өссөн байна.
- Нийт импортын 22 хувийг нефтийн бүтээгдэхүүн, 18 хувийг тоног төхөөрөмж, 12 хувийг барилгын материал, 10 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 8 хувийг суудлын автомашин эзэлж байна.
- Шатахууны импорт 26 хувиар, барилгын материал 14 хувиар, тоног төхөөрөмж 6 хувиар, хүнс 5 хувиар тус тус өссөн нь импортыг нэмэгдүүллээ.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар


- Нефтийн бүтээгдэхүүний импорт 821 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 26 хувиар өссөн байна.
- Тоног төхөөрөмжийн импорт 672 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6 хувиар өссөн байна.
- Суудлын автомашины импорт 296 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 32 хувиар буурлаа.
- Барилгын материалын импорт 422 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 14 хувиар өссөн байна.
- Хүнсний импорт 382 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5 хувиар өслөө.




2026 оны 4 дүгээр сард уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 95 хувийг бүрдүүлээ.




- Нүүрсний экспортын биет хэмжээ 2026 оны 4 дүгээр сард 39.1 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 57 хувиар өслөө.



- Зэсийн баямжлын экспортын биет хэмжээ 2026 оны 4 дүгээр сард 890 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 37 хувиар өслөө.



- Төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 2026 оны 4 дүгээр сард 2,690 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 10 хувиар өслөө.




- Газрын тосны экспортын биет хэмжээ 2026 оны 4 дүгээр сард 1,158 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеийн түвшинд байна.



2026 оны 4 сард хөдөө аж ахуйн экспорт өмнөх оны мөн үеэс 34 хувиар нэмэгдлээ.


ХӨДӨӨ АЖ АХУЙН НИЙТ ЭКСПОРТ

(сая ам.доллар)




ХОНЬ, ЯМААНЫ МАХ

(сая ам.доллар)




САМНАСАН НООЛУУР

(сая ам.доллар)




АРЬС, ШИР

(сая ам.доллар)



БОЛОВСРУУЛСАН МАХ


(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

АДУУ, ҮХРИЙН МАХ


(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

УГААСАН НООЛУУР


(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООС

(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС

(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)



Эх сурвалж: Блүүмберг

ЗЭС

(\$/тонн , Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)



Эх сурвалж: Блүүмберг

ТӨМРИЙН БАЯЖМАЛ


(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламттай төмрийн баяжмал)



Эх сурвалж: Блүүмберг

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Брент)



Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2026 оны 4 дүгээр сарын дундаж үнэ 231 ам.долларт хүрч, өмнөх сараас 4 хувиар, өмнөх оны мөн үеэс 27 хувиар өссөн байна.

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2026 оны 4 дүгээр сарын дундажар 12,823 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 39 хувиар өссөн байна.

- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2026 оны 4 дүгээр сарын дундаж үнэ 109 ам.долларт хүрч, өмнөх сараас 3 хувиар, өмнөх оны мөн үеэс 10 хувиар өссөн байна.


- Брент газрын тосны 2026 оны 4 дүгээр сарын дундаж үнэ 96 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 50 хувиар өслөө.



Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2026 оны 4 сард 9.4 сая тонн нүүрс, 1.6 сая тонн төмрийн хүдэр арилжаалаад байна.

НҮҮРСНИЙ АРИЛЖАА

(сая тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

НҮҮРСНИЙ ДУУДАЖ ҮНЭ


(ам.доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТӨМРИЙН АРИЛЖАА

(мянган тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТӨМРИЙН ДУУДАЖ ҮНЭ

(ам.доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2026 оны 4 дүгээр сарын байдлаар 2023 оноос хойш нийт 68.6 сая тонн нүүрс арилжиж, 6.9 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2025 онд 21.8 сая тонн нүүрс арилжиж, 1.6 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Харин 2026 оны эхний 4 сард 9.4 сая тонн нүүрс борлууллаа.



- 2026 оны 4 дүгээр сард нүүрсний дуудах дундаж үнэ 90 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 97 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 4 дүгээр сард хэлцлийн доод үнэ 21 ам.доллар, дээд үнэ 146 ам.долларт хүрэв.

- 2026 оны 4 дүгээр сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 10.7 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 707 сая ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2025 онд 5.9 сая тонн төмрийг арилжаалж, 380 сая ам.долларын орлого олжээ.
- Харин 2026 оны эхний 4 сард 1.6 сая тонн төмрийн хүдэр борлууллаа.

- Төмрийн хүдэр болон баяжмалын 4 дүгээр сарын дуудах дундаж үнэ 65 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 69 ам.доллар ам.доллар байв.
- Төмрийн төрлөөс хамааран 4 дүгээр сард хэлцлийн доод үнэ 59 ам.доллар, дээд үнэ 89 ам.долларт хүрэв.



Төлбөрийн тэнцэл 2026 оны 3 дугаар сарын байдлаар 96 сая ам.долларын ашигтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2026 оны 4 дүгээр сард өмнөх оноос 2.2 сая ам.доллараар өсөж, 7,327 сая ам.долларт хүрлээ.



- Төлбөрийн тэнцэл 2026 оны 3 дугаар сарын байдлаар 96 сая ам.долларын ашигтай байна.
- Урсгал дансны 182 сая ам.долларын ашигтай байгаа бол, санхүүгийн дансны 168 сая ам.долларын ашигтай байна.

- Гадаад валютын улсын нөөц 2026 оны 4 дүгээр сарын эцэст 7,327 сая ам.доллар болж, өмнөх сараас 139 сая ам.доллар өссөн бол өмнөх оны мөн үеэс 2,192 сая ам.доллараар өслөө.

- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2026 оны 4 дүгээр сард өдөрт дунджаар 0.3 төгрөгөөр суларч, сарын эцэст 3,576 төгрөгт хүрлээ.

- Төв банк 2026 оны 4 дугаар сард 497 сая ам.долларыг зах зээлд нийлүүлээ.
- Төв банк 2026 оны эхний гурван сарын байдлаар мөн үеэс 928 сая ам.доллараар бага буюу нийт 1,668 сая ам.долларыг дуудлага худалдаагаар зах зээлд нийлүүлээд байна.


Тэмдэглэл: Төлбөрийн тэнцлийн статистик 1 сарын хоцрогдолтой зарлагддаг.



Инфляц 2026 оны 4 дүгээр сард 10.1 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар өслөө. Инфляц өмнөх оны мөн үеэс өсөхөд цахилгааны тарифын суурь үеийн нөлөө арилсан боловч тээвэр, хүнсний бүлгийн үнийн өсөлт голлон нөлөөллөө. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад 2.8 хувиар өссөн байна.

ЖИЛИЙН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

САРЫН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


СУУРЬ ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Инфляц 2026 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд 10.1 хувь гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.9 нэгж хувь (28.9 хувь)-ийг бүрдүүлж байна. Сүүлийн сар импортын инфляц өсөхөд машины болон түлшний үнийн өсөлт нөлөөллөө.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 7.2 нэгж хувь буюу 71.1 хувийг эзэлж байна.

- 2026 оны 4 дүгээр сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 2.8 хувиар өслөө.
- Сарын инфляц 2.8 хувь гарахад үхэр, хонь, адууны махны үнэ өмнөх сараас 12.2 хувиар, дизелийн түлшний үнэ 34.0 хувиар тус тус өссөн нь голлох нөлөөтэй байлаа.


- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2026 оны 4 дүгээр сард суурь инфляц 5.9 хувь гарч, нийт инфляцын 3.6 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн сар өссөн үзүүлэлттэй байна.

- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт эрчимжсэнээр жилийн инфляцын 23 хувийг бүрдүүллээ.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар өслөө.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар өслөө.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 41.5 хувиар өслөө.



Олон улсад чингэлэг тээврийн үнэ 2,286 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар буурлаа. Хүнсний үнийн индекс 2026 оны 4 дүгээр сард өмнөх сараас 1.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ХҮНСНИЙ БА ХҮНСНИЙ БУС ИНФЛЯЦ (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Хүнсний инфляц 2026 оны 4 дүгээр сард 19.7 хувь болж, нийт инфляцын 5.4 нэгж хувийг бүрдүүлэв. Хүнсний инфляц эрчимжихэд махны үнийн өсөлт нөлөөллөө.
- Хүнсний бус инфляц 6.5 хувьд хүрч, нийт инфляцын 4.7 нэгж хувийг бүрдүүллээ.


ИМПОРТЫН ИНФЛЯЦ БА ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2026 оны 4 дүгээр сард дунджаар 3,574 төгрөг болж, өмнөх сараас 0.2 хувиар чангарсан байна.
- Импортын бараа бүтээгдэхүүний үнэ 2026 оны 4 дүгээр сард өмнөх сараас 1.9 хувиар өслөө. Үүнд дизель түлшний үнэ өмнөх сартай харьцуулахад 34.0 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН ҮНЭ (1000\$/40 фут контейнер)



Эх сурвалж: Drewry World Container Index

- АНУ-ын тарифын бодлогоос үүдэлтэйгээр дэлхийн чингэлэг тээврийн үнэ өсөөд байсан бол 2025 оны 6 дугаар сараас эхлэн аажмаар буурч эхэллээ.
- Чингэлэг тээврийн үнэ (Drewry World Container Index) 2026 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн байдлаар 40 фут контейнер тутамд 2,286 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар буурсан бол өмнөх 7 хоногоос 3.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Чингэлэг тээврийн үнэ өсөж байгаа нь нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна.

ХҮНСНИЙ ҮНИЙН ИНДЕКС (хувь)



Эх сурвалж: FAO


- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- Хүнсний үнийн индекс 2026 оны 4 дүгээр сард 130.7 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9 хувиар, өмнөх сараас 1.7 хувиар тус тус өссөн байна.
- Сүүлийн сар дэлхийн зах зээл дээр үр тариа, мах, ургамлын тосны үнэ өсөж, сүүн бүтээгдэхүүн, элсэн чихрийн үнэ буурсан байна. Үүнд дэлхийн зах зээл дээр түлшний үнэ өссөн нь нөлөөлжээ.



Нэгдсэн төсвийн орлого 2026 оны 4 дүгээр сарын байдлаар 10,206.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 13.8 хувиар, зарлага 10,372.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 21.4 хувиар өслөө.

ТӨСВИЙН ОРЛОГО


(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ТАТВАРЫН ОРЛОГО


(татварын төрлүүдээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ТӨСВИЙН ЗАРДАЛ

(зардлын ангиллаар, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

УРСГАЛ ЗАРДАЛ

(зардлын ангиллаар, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

- 2026 оны эхнээс АМНАТ-ийн 65 хувийг Ирээдүйн өв санд хуваарилж эхэлсэн нь сангуудын орлогын хуримтлал өмнөх оны мөн үеэс 2.6 дахин өсөхөд нөлөөллөө.
- Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2026 оны 4 дүгээр сарын байдлаар 8.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 455.9 тэрбум төгрөг буюу 5.4 хувиар өссөн байна.
- Татварын орлого 2026 оны эхний 4 сард 8.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 344.5 тэрбум төгрөг буюу 4.3 хувиар өсөхөд НД болон НӨАТ-ын орлогын өсөлт нөлөөллөө.

- Дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ өндөр байгаатай холбогдуулан АМНАТ 1.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 815.1 тэрбум төгрөг буюу 1.9 дахин өссөн нь төсвийн орлого өсөхөд эерэг нөлөө үзүүллээ.
- Харин ААНОАТ-н орлого өмнөх оны мөн үеэс 275.0 тэрбум төгрөгөөр (15.4 хувь), онцгой албан татварын орлого өмнөх оны мөн үеэс 108.3 тэрбум төгрөгөөр (28.6 хувь) буурсан байна.

- Нэгдсэн төсвийн зарлага 2026 оны 4 дүгээр сард 10.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.8 их наяд төгрөг буюу 21.4 хувиар өссөн байна.
- Нийт өсөлтийн 10.6 нэгж хувийг урсгал зардлын өсөлт, 10.3 нэгж хувийг хөрөнгийн зардлын өсөлт тайлбарлаж байна.
- Хөрөнгийн зардал 1.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 877.7 тэрбум төгрөг буюу 2.2 дахин өсөхөд барилга байгууламжийн зардлын өсөлт голлон нөлөөлсөн байна.


- Урсгал зардлын өсөлтөд цалингийн зардал 2.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 399.4 тэрбум төгрөг буюу 19.6 хувиар, тэтгэвэр, тэтгэмжийн нийт зардал 3.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 349.7 тэрбум төгрөг буюу 12.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.
- Харин засгийн газрын урсгал шилжүүлэг 936.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 51.9 тэрбум төгрөгөөр (5.3%▼), мэргэжлийн үйлчилгээний төлбөр 190.3 тэрбум төгрөгт хүрч, 66.7 тэрбум төгрөгөөр (26.0%▼), бараа үйлчилгээний бусад зардал 270.9 тэрбум төгрөгт хүрч, 51.1 тэрбум төгрөгөөр (15.9%▼) тус тус буурчээ.



Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2026 оны 4 дүгээр сарын байдлаар 1,424.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ


(их наяд төгрөг)



- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2026 оны 4 дүгээр сарын байдлаар 1.4 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарахад төрийн албан хаагчдын цалин хөлс болон тэтгэврийг нэмэгдүүлсэн нь голлох нөлөө үзүүллээ.

ТӨСВИЙН ТЭНЦЭЛ


(их наяд төгрөг)



- Нэгдсэн төсвийн нийт тэнцэл 2026 оны 4 дүгээр сарын байдлаар 165.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс төсвийн алдагдал 587.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Төсвийн үндсэн тэнцэл нь нийт зардлаас хүүгийн зардлыг хасаж тооцсон тэнцэл бөгөөд 2026 оны 4 дүгээр сард 332.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.
- Энэ нь хүүгийн төлбөрийг эс тооцвол төсвийн суурь үйл ажиллагаа ашигтай гарсныг илэрхийлж байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(Зүүн тэнхлэг: их наяд төгрөг
Баруун тэнхлэг: ДНБ-д эзлэх хувь)



- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар 35.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар өсөж, ДНБ-ий 37.5 хувьд хүрсэн байна.
- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(их наяд төгрөг)

	2025.1	2026.1	Өсөлт/Бууралт
Засгийн газрын нийт өр	34.6	35.8	3.4%
ДНБ-д эзлэх хувь	37.3%	37.5%	0.2%
Засгийн газрын дотоод өр	0.4	1.1	160.8%
Засгийн газрын гадаад өр	31.4	32.0	1.9%
Үнэт цаас	8.7	9.1	4.5%
Зээл	22.7	22.9	0.9%
Засгийн газрын бусад өр	2.8	2.7	-2.0%
ЗГ өрийн баталгаа	0.2	0.2	-7.9%
Нийслэлийн үнэт цаас	2.6	2.6	-1.6%


Эх сурвалж: Сангийн яам

- Засгийн газрын нийт өрийн 89.4 хувийг гадаад өр, үүний дотор 63.9 хувийг гадаад зээл, үлдсэн 25.5 хувийг гадаад үнэт цаас бүрдүүлж байна.
- Нийт өрийн бүтцэд гадаад өр давамгайлж байгаа нь валютын ханшийн хэлбэлзэл, олон улсын зах зээлийн нөхцөл байдал, хүүгийн түвшний өөрчлөлтөөс шууд хамаарах тул өрийн эрсдэл харьцангуй өндөр байгааг илэрхийлж байна.




Мөнгөний нийлүүлэлт 2026 оны 4 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар өсөж, 50.7 их наяд төгрөгт хүрлээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2026 оны 4 дүгээр сард 46.0 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 16.3 хувьд хүрлээ.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




Эх сурвалж: Монголбанк

ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




Эх сурвалж: Монголбанк

ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (хувь)



Эх сурвалж: Монголбанк

ХҮҮГИЙН ТҮВШИН (жигнэсэн дундаж хувь)



Эх сурвалж: Монголбанк

- Мөнгөний нийлүүлэлт 2026 оны 4 дүгээр сарын эцэст 50.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 13.5 нэгж хувь, гадаад валютын хадгаламж ба харилцах 5.2 нэгж хувь, төгрөгийн харилцах 5.8 нэгж хувь, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.2 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.

- Нийт хадгаламж 33.0 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 25.0 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 27.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 25.0 хувиар өслөө.
- Гадаад валютын хадгаламж 5.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар өслөө.


- Банкнудын зээлийн үлдэгдэл 2026 оны 4 дүгээр сарын эцэст 46.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.2 хувь буюу өмнөх оны мөн үеэс 0.01 хувиар өслөө.

- Банкнудын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2026 оны 4 дүгээр сард 17.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өссөн бол өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурсан байна.
- Банкнудын шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2026 оны 4 дүгээр сард 11.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар буурсан бол өмнөх сараас 0.04 нэгж хувиар өссөн байна.




Банкуудын ногоон зээлийн нийт үлдэгдэл 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар 2.5 их наяд төгрөгт хүрч, өмнө улирлаас 2.9 хувиар нэмэгджээ. Банкуудын нийт зээлийн үлдэгдэлд ногоон зээлийн эзлэх хувь 5.7 хувьд хүрлээ.

НОГООН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЛИЙН ӨСӨЛТ (улирлын өсөлт, хувь)




Эх сурвалж: Монголбанк

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ (хувь)



Эх сурвалж: Монголбанк

НИЙТ ЗЭЭЛД НОГООН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЛИЙН ЭЗЛЭХ ХУВЬ (хувь)



Эх сурвалж: Монголбанк

НОГООН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ (салбараар, хувь)




Эх сурвалж: Монголбанк

- 2026 оны I улирлын байдлаар ногоон зээлийн үлдэгдэл өмнөх улирлаас 9.2 хувиар өсөж, өсөлтийн эерэг хандлага үргэлжилж байна. Хэдий 2022-2023 оны огцом өсөлттэй үеэс харьцангуй саарсан ч ногоон санхүүжилт банкны салбарт тогтвортой байр суурь эзэлж эхэлж буйг харуулж байна.
- Ногоон зээлийн чанаргүй зээлийн хувь 2.1 хувь байгаа нь банкны системийн дундаж болох 5.1 хувиас харьцангуй бага түвшинд байна. Сүүлийн жилүүдэд ногоон зээлийн чанаргүй зээлийн хувь тогтвортой буурсан нь уг төрлийн санхүүжилтийн эрсдэл харьцангуй бага, чанарын үзүүлэлт илүү сайн байгааг харуулж байна.
- Ногоон зээлийн үлдэгдэл нийт зээлийн 5.7 хувийг эзэлж, сүүлийн жилүүдэд тогтвортой өссөн байна. Гэсэн ч банкны салбарын нийт зээлийн багцтай харьцуулахад ногоон зээлийн хэмжээ харьцангуй бага хэвээр байгаа нь ногоон санхүүжилтийн орон зай цаашид тэлэх боломжтойг харуулж байна.
- 2026 оны I улирлын байдлаар ногоон зээлийн үлдэгдлийн дийлэнх буюу 58.8% нь эрчим хүчний хэмнэлтийн чиглэлд төвлөрч байна. Мөн тогтвортой ХАА, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлалын салбар 18.2 хувийг эзэлж байгаа бол сэргээгдэх эрчим хүчний салбарын эзлэх хувь 8.9% байна. Энэ нь ногоон санхүүжилт харьцангуй цөөн чиглэлд төвлөрч, бусад ногоон салбаруудын санхүүжилтийн орон зай харьцангуй бага хэвээр байгааг харуулж байна.




Шинээр олгосон ногоон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 14.1 хувь, жигнэсэн дундаж хугацаа 54.0 сар байна. Ногоон төгрөгийн зээл нь банкны зээлтэй харьцуулахад бага хүүтэй, урт хугацаатай олгогдож байгаа нь тогтвортой, урт хугацааны ногоон хөрөнгө оруулалтыг дэмжих хандлага нэмэгдэж байна.

ШИНЭЭР ОЛГОСОН ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙН ХҮҮ (жигнэсэн дундаж хувь, жилээр)



Эх сурвалж: Монголбанк

ШИНЭЭР ОЛГОСОН ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙН ХУГАЦАА (жигнэсэн дундаж хугацаа, сар)



Эх сурвалж: Монголбанк

- Шинээр олгосон ногоон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 14.1 хувь байгаа нь банкны зээлийн дундаж хүү болох 17.4 хувиас доогуур түвшинд байна. Сүүлийн жилүүдэд ногоон зээлийн хүү нийт банкны зээлийн хүүгээс харьцангуй бага хадгалагдаж байгаа нь ногоон санхүүжилтийг илүү таатай нөхцөлөөр дэмжих хандлага үргэлжилж байгааг харуулж байна.

- Шинээр олгосон ногоон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хугацаа 54.0 сар байгаа нь банкны зээлийн дундаж хугацаа болох 38.7 сараас урт байна. Ногоон зээлүүд харьцангуй урт хугацаатай олгогдож байгаа нь эрчим хүчний хэмнэлт, тогтвортой хөрөнгө оруулалт зэрэг урт хугацааны өгөөжтэй төслүүдийг санхүүжүүлэх хандлага нэмэгдэж байгааг илтгэж байна.

НОГООН БОНДУУДЫН МЭДЭЭЛЭЛ – 2026.03

Арилжааны банк (2023.12.15)

НОГООН БОНД - 1

17 тэрбум ₮

16% | 3 жил

Арилжааны банк (2024.10.17)

НОГООН БОНД - 2

25 сая \$

SOFR+3.4% | 3 жил

Хог хаягдлыг дахин боловсруулах салбар (2024.11.06)

НОГООН ДАХИН БОЛОВСРУУЛАЛТЫН БОНД (ТРАНЧ-1)

11 сая \$

10% | 3 жил

Хог хаягдлыг дахин боловсруулах салбар (2025.01.03)

НОГООН ДАХИН БОЛОВСРУУЛАЛТЫН БОНД (ТРАНЧ-2)

4 сая \$

10% | 3 жил

Арилжааны банк (2024.10.23)

БАТАЛГААЖААГУЙ НОГООН БОЛОН НИЙГМИЙН БОНД

50 сая \$

9.5% | 5 жил

Арилжааны банк (2025.01.02)

НОГООН БОЛОН НИЙГМИЙН БОНД


50 сая \$

8% | 5 жил



Ажиллагчдын тоо 1 сая 340 мянгад хүрч буурч, ажилгүй иргэдийн тоо өссөн нөлөөгөөр ажиллах хүч буурч, ажиллах хүчний оролцооны түвшин 60.4 хувь болж буурлаа.

АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ӨӨРЧӨЛӨТ, ХҮЙСЭЭР (мянган хүн, хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ӨӨРЧӨЛӨТ, САЛБАРААР (мянган хүн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ДУНДАЖ ЦАЛИН, ГОЛЧ ЦАЛИН, БОДИТ ЦАЛИН (мянган төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 39 мянга буюу 2.8 хувиар буурч 1 сая 340 мянгад хүрч ажиллагчдын тоо 17 улирлын дараа анх удаа буурч 2024 оны түвшинд хүрлээ.
- 2026 оны 1 дүгээр улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 31 мянгаар, эмэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 9 мянгаар тус тус буурсан байна.

- Ажиллагчдын тооны өсөлтөд уул уурхайн салбарын өсөлтийн нөлөөгөөр салбарын ажиллагчдын тоо өссөн, үйлчилгээний бусад салбар, цахилгаан, усны салбарын ажиллагчид нэмэгдсэн нь нийт ажиллагчдыг дэмжсэн байна.
- Харин хөдөө аж ахуйн, боловсруулах, тээвэр, худалдааны салбарын ажилчдын тоо буурсан нь нийт ажиллагчдын тоо буурахад голлон нөлөөлөв.

- Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 1.6 мянгаар өссөнөөр ажилгүйдлийн түвшин 5.7 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өссөн байна.
- Харин ажиллах хүчний оролцооны түвшин ажиллагчдын тоо буурсан нөлөөгөөр өмнөх оны мөн үеэс 1.6 нэгж хувиар буурч 60.4 хувьд хүрээд байна.

- Дундаж цалингийн хэмжээ 2026 оны 4 дүгээр сарын байдлаар 2 сая 632 мянган төгрөг байна.
- Улсын голч цалин 2 сая 263 мянган төгрөг (дундаж цалингаас 369 мянган төгрөгөөр бага) байна. Энэ нь ажилчдын талаас илүү нь 2.3 сая төгрөгөөс бага цалин авч байгааг илэрхийлж байна.
- Хэрэглээний үнийн индексээр засварлагдсан бодит цалин 2 сая 95 мянган төгрөгт хүрлээ.


(Энд ХҮИ 2023=100)



Өрхийн бодит орлого 6.3 хувиар өсөв.


ӨРХИЙН БОДИТ ОРЛОГЫН ӨСӨЛТ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


ӨРХИЙН НЭРЛЭСЭН ОРЛОГО, ЗАРЛАГА БОЛОН ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ӨРХИЙН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ОРЛОГО


(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ӨРХИЙН НЭРЛЭСЭН ОРЛОГО

(сая төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Өрхийн бодит орлогын өсөлтийн эрчим өмнөх улирлаас сайжирч, 6.3 хувиар өсөв*.
- Өрхийн орлогын өсөлтөд иргэдийн цалингийн орлого өмнөх оны мөн үеэс нэрлэсэн дүнгээр 224.0 мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 80.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

- Өрхийн орлогын өсөлт зарлагын өсөлтөөс дээгүүр байгаа хэдий ч иргэдийн хадгаламжийн өсөлт үргэлжлэн удааширсаар байна.

- Хөдөөгийн өрхийн 42 хүртэлх хувь, нийслэлийн өрхийн 20 орчим хувь 2.1 сая төгрөг хүртэлх орлоготой байна.
- Хөдөөгийн өрхийн 16 хувь нь 4 сая төгрөгөөс дээш орлоготой байгаа бол нийслэлийн өрхийн 45 хувь нь 4.0 сая төгрөгөөс дээш хэмжээний орлоготой байна.

- Хот, хөдөөгийн нэрлэсэн орлогын зөрүү хадгалагдаж байна. Үүнд, 2025 оны 01 дүгээр улиралд нийслэлийн өрхийн дундаж орлого хөдөөгийн өрхөөс 1.5 дахин өндөр байсан бол 2026 оны 01 дүгээр улирлын байдлаар зөрүү хадгалагдаж, 1.6 гарлаа. Хөдөөгийн өрхийн орлогын өсөлтийн эрчим нэмэгдэж байгаа ч орлогын зөрүү хадгалагдсаар байна.


Тэмдэглэл: ҮСХ-ноос өрхийн бодит орлогыг 2026 оны I улирлаас 2023 оны зэрэгцүүлэх үнээр тооцож эхэлсэн, 2021 улирлаас - 2025 оны IV улирлын бодит орлого нь 2020 оны зэрэгцүүлэх үнээр тооцогдсон.

Тэмдэглэл: ҮСХ-ноос өрхийн бодит орлого, зарлагыг 2026 оны I улирлаас 2023 оны зэрэгцүүлэх үнээр тооцож эхэлсэн, 2022 I улирлаас - 2025 оны IV улирлын бодит орлого, зарлага нь 2020 оны зэрэгцүүлэх үнээр тооцогдсон.



Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2026 оны 1 дүгээр улиралд 268.3 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 367 аар буюу 0.1 хувиар буурлаа.

НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ААН-ИЙН ТОО



- Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2026 оны 1 дүгээр улиралд 268.3 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 367 оор буурлаа.
- Үйл ажиллагаа явуулж буй болон үйл ажиллагаа эхлээгүй ААН-үүд өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар нэмэгдсэн бол, үйл ажиллагаа зогсоосон болон олдохгүй байгаа аж ахуйн нэгжүүд 10.9 хувиар буурсан байна.
- Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо буурсан хэдий ч идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэж буй нь эдийн засгийн идэвхжилттэй байгааг харуулж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ


(ААН-ийн тоо, салбараар)



- Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо худалдааны салбарт 2.2 мянга, үйлчилгээний салбарт 2.1 мянгаар нэмэгдлээ.
- Мөн хөдөө аж ахуйг дэмжих бодлого хэрэгжүүлсэн зэрэгтэй холбоотойгоор тус салбарын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 13 хувиар өссөн байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТОО


(мянга, ажиллагчдын тоогоор)



- Үйл ажиллагаа явуулж буй 117.3 мянган ААН-ийн 102.0 мянга нь бичил буюу 1-9 ажилтантай ААН-үүд байна.
- Мөн 1-9 ажилтантай ААН-үүдийн өсөд үйл ажиллагаа явуулж буй нийт ААН-ийн өсөлтийг бүрдүүлж байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС




(улирлаар, 2018=100)



- Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 2026 оны 1 дүгээр улиралд 107.2 болж өмнөх оны мөн үеэс 2.8 нэгжээр өслөө.
- ХИИ-ийг задлан харвал хэрэглэгчдийн эдийн засгийн одоогийн нөхцөлийн үнэлэмжийг харуулдаг Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 21.1 нэгжээр буурсан.
- Мөн эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлтийг харуулдаг Ирээдүйн хүлээлтийн индекс 10.5 нэгжээр өссөн бөгөөд үүнд бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлогын хүлээлт өссөн нь нөлөөллөө.



ОХУ-ын эдийн засаг 2026 оны 1 дүгээр улиралд 0.2 хувиар агшлаа. Инфляцын түвшин 2026 оны 4 дугаар сард 5.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 4.7 нэгж хувиар буурсан байна.




- ОХУ-ын эдийн засаг 2026 оны 1 дүгээр улиралд -0.2 хувиар агшиж, өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар буурлаа.
- 2026 оны 3 дугаар сарын байдлаар экспорт 41.1 тэрбум ам.доллар, импорт 27.1 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 14.0 тэрбум ам.долларын ашигтай байна.
- Экспорт 2026 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 16 хувиар өслөө.
- Импорт 2026 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 17 хувиар өслөө.
- ОХУ-ын инфляц зорилтот түвшин болох 4 хувиас өндөр хэвээр байна.
- Инфляцын түвшин 2026 оны 4 дүгээр сард 5.6 хувь болж, өмнөх сараас 0.3 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 4.7 нэгж хувиар буурсан байна.
- Жилийн инфляцын түвшин 2025 онд 8.7 хувьд хүрч, өмнөх оноос 0.3 нэгж хувиар өслөө.
- ОХУ-ын төв банкнаас 4 дүгээр сарын 24-ний өдөр бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулж, 14.5 хувьд хүргэх шийдвэр гаргасан.
- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2026 оны 4 дүгээр сард 48.1 болж, өмнөх сараас 0.2 нэгжээр буурлаа.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2026 оны 3 дугаар сарын байдлаар 2.3 хувь болж, өмнөх сараас 3.2 нэгж хувиар өслөө.



Хэдийгээр дотоод эрэлт сул хэвээр байгаа ч экспорт, дотоодын эрэлт нэмэгдсэнээр БНХАУ-ын эдийн засаг 2026 оны эхний улиралд 5.0 хувиар өслөө.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(хувь)



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- БНХАУ-ын эдийн засаг 2026 оны эхний улиралд 5.0 хувиар өслөө.
- 2026 оны 4 дүгээр сард экспорт 14.1 хувиар, импорт 25.3 хувиар тус тус өсөж өмнөх сараас чангарсан үзүүлэлттэй байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистикийг нэгтгэгдэн зарлагдаг.

АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ ӨСӨЛТ

(хувь)



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн гарц 2026 оны 4 дүгээр сард 4.1 хувиар өсөж, өмнөх сараас өсөлт саарлаа.
- Хэрэглээний төлөвийг илэрхийлэх жижиглэн худалдааны борлуулалт оны 4 дүгээр сард 0.2 хувь болж саарсан байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистикийг нэгтгэгдэн зарлагдаг.

ИНФЛЯЦ

(хувь)




Эх сурвалж: Блүүмберг

- Хэрэглээний үнийн индекс 2026 оны оны 4 дүгээр сард 1.2 хувь гарч дефляцийн бүсээс гарлаа.
- Үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2026 оны 4 дүгээр сард 2.8 хувь гарч, үнийн уналтын бүсээс гарч, огцом өслөө.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI) (нэгж)

—●— Нэгдсэн PMI
—●— Аж үйлдвэрийн салбарын PMI
—●— Аж үйлдвэрийн бус салбарын PMI
--- Босоо утга



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2026 оны 4 дүгээр 50.3 болж, тэлэлтийг илэрхийлж байна.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас өсөж 50 түвшинд байна.

Тэмдэглэл: Тус индекс нь богино хугацааны идэвхжилийг илэрхийлэх бөгөөд ААН-үдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүний эдийн нөөц зээг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ